

Аудит хийгдсэн байгууллага:
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

Огноо: 2024 он

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

“УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН БАГЦЫН
2023 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА”-НЫ ХЭРЭГЖИЛТ

2024 он

Аудит хийсэн байгууллага:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

Аудит хийгдсэн байгууллага: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтэс

Аудитын төрөл: Дотоод аудит

Аудит хийх хугацаа: 2024 оны 05 дугаар сарын 01-нээс 19-ний өдрүүд

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн дарга:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын дарга

Т.Баасанпүрэв

Гишүүд:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын ахлах шинжээч

И.Баттуяа

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын мэргэжилтэн

Л.Мөнхгэрэл

1.ТАНИЛЦУУЛГА

2.АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

- 2.1 Аудитын зорилго
- 2.2 Аудитын цар хүрээ
- 2.3 Аудитын арга, аргачлал

3.БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

- 3.1 Засаглалын удирдлагын талаар
- 3.2 Эрсдэлийн удирдлагын талаар
- 3.3 Дотоод хяналтын талаар

4.АУДИТЫН ҮР ДҮН

- 4.1 Илэрсэн асуудлууд

5.НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН БАГЦЫН 2023 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

1. ТАНИЛЦУУЛГА

Уул уурхайн сайдын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр А/31 дүээр тушаалаар баталсан “Дотоод аудитын төлөвлөгөө”-ний дагуу ХШҮДАГ-ын ахлах шинжээч И.Баттуяа, Л.Мөнхгэрэл нар 2024 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн ажлын 14 хоногийн хугацаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын 2023 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд дотоод аудит хийв.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А/31 дүгээр тушаалаар батлагдсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, дотоод аудитын газрын 2024 оны дотоод аудитын төлөвлөгөөний дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт, архивын болон албан хэргийн хөтлөлтийн үндсэн заавар, стандартаар тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэхэд дотоод аудит хийж, эрсдэлийг бууруулах, эрх зүйн зөрчил, дутагдлаас урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааг сайжруулахад оршино.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/293, 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/196, 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/376, дугаар тушаалаар тус тус батлагдсан “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай”, “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тушаалын хэрэгжилтэд дотоод аудит хийж гүйцэтгэхдээ 2023 онд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан үнэлгээний хороодын зохион байгуулалт, үйл ажиллагаа, сонгон шалгаруулалтын бичиг баримтыг хамруулсан.

Төлөвлөгөөнд тусгагдсан “Эрдэм шинжилгээ, судалгааны ажил-1” Улсын төсвийн хөрөнгөөр Ханбогдын дүүрэгт 2023 онд гүйцэтгэх геофизикийн судалгааны цогцолбор ажлын төслийг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалтын баримт бичгийг Авилгатай тэмцэх газраас хянаж байгаа тул дотоод аудитын шалгалтад багтаагүй болно.

2.3 Аудитын арга, аргачлал

- “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хууль;
- Засгийн газрын “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 2021 оны 124 дүгээр тогтоол;
- Сангийн сайдын “Тендерийн жишиг баримт бичиг батлах тухай” 2021 оны 124, 144, 145, 146 дугаар тушаалууд;
- Сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам”;

- Сангийн сайдын 2023 оны 250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам;
- Улсын салбарын дотоод аудитын аргачлал;

Дээрх эрх зүйн эх сурвалж, баримт бичгийн хүрээнд худалдан авалтын баримт материалтай нэг бүрчлэн танилцаж, тулган баталгаажуулж, нягтлан шалгасны үндсэн дээр дүгнэлт гаргасан бөгөөд аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох баримт, холбогдох тайлан, мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

Сайдын багцад 9,077,723.3 мянган төгрөгийн 48 бараа, ажил, үйлчилгээг төлөвлөн 8,802,008.11 мянган төгрөгийн 43 бараа, ажил, үйлчилгээг худалдан авч 275.7 сая төгрөгийн төсвийн хэмнэлтийг гаргаж ажилласан, худалдан авалтын явцыг тухай бүр шилэн дансанд байршуулж ажилласан байна.

3.1 Засаглалын талаар

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсээс тайлант жилийн төсвийн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааг төлөвлөж, харьяа агентлагууд болон үнэлгээний хороодыг зохион байгуулалтын чиг үүргээр хангах, хуулийн хүрээнд зохион байгуулах, хугацаандаа тайлагнаж ажиллах үүрэг хүлээнэ.


Үнэлгээний хороод тайлант жилд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгж байгууллагыг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан сонгон шалгаруулж, тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүр цахим системд нийтлэх, захиалагчийг зөвлөмжөөр хангах, тендер шалгаруулалтын хувийн хэргийг үүсгэх, архивд хүлээлгэн өгөх зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ.

4. АУДИТЫН ҮР ДҮН

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын урсгал зардал, хөрөнгийн зардал болон өөрийн хөрөнгөөр санхүүжих 9,077,723.3 мянган төгрөгийн 48 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээнээс Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь 2023 онд 3,762,424.2 мянган төгрөгийн өртөг бүхий 18 бараа, ажил, үйлчилгээ, Ашигт малтмал, газрын тосны газар 759,719.6 2 мянган төгрөгийн өртөг бүхий 16 бараа, ажил, үйлчилгээ, Үндэсний геологийн алба 4,555,579.5 мянган төгрөгийн өртөг бүхий 14 бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн.

Захиалагчийн 2023 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөний дагуу худалдан авалтыг зохион байгуулахдаа 500,679.0 мянган төгрөгийн өртөг бүхий нээлттэй тендер шалгаруулалт 2, 7,370,751.6 мянган төгрөгийн өртөг бүхий зөвлөх үйлчилгээ 5, 175,693.3 мянган төгрөгийн өртөг бүхий харьцуулалт 5, 418,879.5 мянган төгрөгийн өртөг бүхий шууд худалдан авалт 24, 265,612.4 мянган өртөг бүхий ерөнхий гэрээний нөхцөл /цахим дэлгүүр/-өөр 7, нийт 8,801,615.71 мянган төгрөгийн 43 нэр төрлийн бараа, ажил үйлчилгээг авсан байна.

ГҮЙЦЭТГЭЛ:



“Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2023 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд дотоод аудит хийхэд нээлттэй тендер шалгаруулалтын баримт бичигт дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Илэрсэн асуудал 1.	Үнэлгээний хорооны сонгон шалгаруулалтын баримт бичгийн иж бүрдэл дутуу байна.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй.
Бодит байдал: Нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулсан Программ хангамжийн үйлчилгээний сонгон шалгаруулалтын баримт материалд ❖ Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүдийн “Ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”, ❖ Тендерт шалгарсан болон шалгараагүй тухай оролцогчдод хүргүүлсэн мэдэгдлийг тус тус хавсаргаагүй, ❖ Цахим системд гэрээг байршуулаагүй.	
Барилгын засварын ажлын сонгон шалгаруулалтын баримт материалд ❖ Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүн Баянжаргалын “Үнэлгээний хороонд орж ажиллахыг зөвшөөрсөн мэдэгдэл”, ❖ Үнэлгээний хорооны гишүүдийн хянах хуудас, үнэлгээний хуудсыг тус тус хавсаргаагүй. ❖ Тендерт шалгарсан болон шалгараагүй тухай оролцогчдод хүргүүлсэн мэдэгдлийг цахим системд хоцорч мэдээлсэн.	

- ❖ Цахим системд гэрээг байршуулаагүй.

“Эрдэм шинжилгээний ажил-2” зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтын баримт материалд

- ❖ Тендерийн хүчинтэй хугацаанд багтааж Багц-1 “Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд авах” зөвлөх үйлчилгээний тендерийн үр дүнг мэдэгдээгүй, гэрээг байгуулаагүй,
- ❖ Цахим системд гэрээг байршуулаагүй.

Ашигт малтмал, газрын тосны газрын “Галт хана Palo Alto-820 лиценз худалдан авах”, “Цайны газар, ариун цэврийн өрөөнүүдийн засварын ажил”, “Техник үйлчилгээний төвийн гражийн 3, 4, 5 дугаар хаалгуудыг солих” бараа, ажил, үйлчилгээ:

- ❖ Тендерт шалгарсан болон шалгараагүй тухай оролцогчдод хүргүүлсэн мэдэгдлийг цахим системд хоцорч мэдээлсэн.
- ❖ Цахим системд гэрээг байршуулаагүй.

Үндэсний геологийн албаны “Геологи хайгуулын судалгааны ажил”, “Мэдээлэл технологийн үйлчилгээ”:

- ❖ Цахим системд гэрээг байршуулаагүй.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24.5 заалт,
2. Үнэлгээний хороонд томилогдсон гишүүн бүр Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийн загварын дагуу тухайн худалдан авах ажиллагаанд оролцоход ашиг сонирхлын зөрчилтэй эсэхээ мэдэгдэнэ.
3. Архивын тухай хууль, “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-д нийцүүлэн бүрдүүлбэрийг хангаж архивлах.

Асуудлын үндсэн шалтгаан:

Тендерийн үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга үнэлгээний хорооноос гарсан шийдвэрийг албажуулах чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй, хуулийн мэдлэг сул байна. Үнэлгээний хорооноос гарсан зөвлөмжийг захиалагч хугацаа алдаж хэрэгжүүлсэн.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Байгууллагын үнэлэмж буурах, Удирдах дээд байгууллагаас хуулийн хэрэгжилтээр хариуцлага тооцуулах.

Зөвлөмж:

-Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2023 оны 250, 254 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам” болон бусад эрх зүйн актын хүрээнд зохион байгуулах.

-Байгууллагын албан хаагчдыг худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх.

Илэрсэн асуудал 2.	Сайдын багцын Худалдан авах ажиллагаа төлөвлөсөн хугацаандаа эхлээгүй байна.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй.
Бодит байдал: Сайдын багцын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 13 бараа, ажил, үйлчилгээний 7 зөвлөх үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулахдаа төлөвлөгөөт хугацаанд эхлээгүй. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны барилгын засварын ажил: ❖ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны барилгын засварын ажил гүйцэтгэх тендерийн ажлын даалгавар 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр баталсан. ❖ Тендерийн урилгыг 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр нийтлэх байсныг 2023 оны 6 дугаар сарын 05-ны өдөр нийтэлсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны “Эрдэм шинжилгээний ажил-2” зөвлөх үйлчилгээний ажил: ❖ Багц-1 “Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд авах” зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг баталсан хугацаа байхгүй, ❖ Багц-2 “Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр баталсан. ❖ Тендерийн урилгыг 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр нийтлэх байсныг 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр нийтэлсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2022 оны нэгтгэл тайлан боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажил: ❖ “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2022 оны нэгтгэл тайлан боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр баталсан. ❖ Тендерийн урилгыг 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр нийтлэх байсныг 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр нийтэлсэн. Ашигт малтмал, газрын тосны газрын “Тээвэр шатахуун” нийлүүлэх: ❖ Сонгон шалгаруулалтыг хуулийн хугацаанд зохион байгуулж ажилласан боловч захиалагчтай байгуулсан гэрээг цахим системд нийтлээгүй. Ашигт малтмал, газрын тосны газрын “Хөдөлмөр хамгаалал”-ын бараа нийлүүлэх: ❖ Босго үнийн дагуу тухайн бараа ажил үйлчилгээг тендер шалгаруулалтын харьцуулалтын аргаар зохион байгуулах байсныг шууд худалдан авалтаар зохион байгуулсан. Ашигт малтмал, газрын тосны газрын “Харуул, хамгаалалт”, “Галт хана Palo Alto-820 лиценз худалдан авах”, “Цайны газар, ариун цэврийн өрөөнүүдийн засварын ажил”: ❖ Тендерийн урилгыг 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдөр нийтлэх байсныг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр нийтэлсэн. ❖ Тендерийн урилгыг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр нийтлэх байсныг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр нийтэлсэн. ❖ Тендерийн урилгыг 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр нийтлэх байсныг 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр нийтэлсэн.	

Төлөөлөгчийн үйл ажиллагааны дэмжлэг данснаас санхүүжих 2 төсөл, арга хэмжээг 2023.06.12, 2023.06.30-ны өдөр зарлахаар төлөвлөсөн боловч зохион байгуулаагүй.

Үндэсний геологийн албаны “Бичиг хэрэг”, “Мэдээлэл технологийн үйлчилгээ”:

- ❖ Тендерийн урилгыг 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр нийтлэх байсныг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр нийтэлсэн.
- ❖ Тендерийн урилгыг 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр нийтлэх байсныг 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр нийтэлсэн.
- ❖ Геологи хайгуулын судалгааны ажлыг 2023.02.27-ны өдөр нийтлэх байсныг 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр нийтэлсэн.

Геологийн судалгааны аргачлал хяналтын зардлаас санхүүжүүлэх 3 төсөл, арга хэмжээг 2023.02.27-ны өдөр зарлахаар төлөвлөсөн боловч зохион байгуулаагүй.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/293, 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/196, 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/376, дугаар тушаалаар тус тус батлагдсан “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай”, “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тушаалыг хангаж ажиллах.

Асуудлын үндсэн шалтгаан:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Үндэсний геологийн албаны удирдлага удаан хугацаанд томилогдоогүй, Үнэлгээний хорооны зохион байгуулалт, чиг үүргээр хангаж байгаа асуудал хариуцсан нэгжийн уялдаа холбоо сул.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

- Байгууллагад шаардлагатай бараа, ажил, үйлчилгээг цаг хугацаандаа авахгүй байх.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүйгээс хариуцлага тооцуулах.

Зөвлөмж:

- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2023 оны 250, 254 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам” болон бусад эрх зүйн актын хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулах.
- ✓ Худалдан авах ажиллагааг үнэн зөв, бодитой төлөвлөх. Төлөвлөсөн хугацаанд зохион байгуулж ажиллах.

Дүгнэлт

1. Худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдсан нийт 48 бараа, ажил, үйлчилгээнээс нээлттэй тендер шалгаруулалтаар 2, зөвлөх үйлчилгээ 5, ерөнхий гэрээний нөхцөл /цахим дэлгүүр/-өөр 7, харьцуулалтын аргаар 5, шууд худалдан авалтаар 24 бараа, ажил, үйлчилгээг хуулийн хүрээнд зохион байгуулж 8,801,615.71 мянган төгрөгийн худалдан авалтыг хийж төлөвлөгөөнөөс 275.7 сая төгрөгийн төсвийн хэмнэлт гаргаж ажилласан байна.
2. Төрийн Худалдан авах ажиллагааны цахим систем, зохион байгуулалтын талаар үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нарыг чиг үүргээр хангаж, тендерийн ерөнхий

- мэдээллийг шилэн дансанд байршуулан олон нийтэд мэдээлэн ил тод байдлыг хангаж ажилласан байна.
3. Үнэлгээний хороо гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа батлагдсан төлөвлөгөөнөөс хугацаа хоцорч урилга, үр дүнг нийтэлжээ.
 4. Үнэлгээний хорооны сонгон шалгаруулалтын баримт бичгийн бүрдэл дутуу хувийн хэрэг үүсгэсэн зэрэг нийтлэг дутагдлууд байна.
 5. Худалдан авах ажиллагааг Сангийн сайдын 2023 оны 254 дүгээр тушаалаар баталсан "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам"-д нийцүүлэн хуулийн хугацаандаа тайлагнасан байна.

ЗӨВЛӨМЖ

1. Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан цаг хугацаа, төсөвт багтааж худалдан авалтыг зохион байгуулах,
2. Төлөвлөлт оновчтой байх. Ажлын даалгавар зураг, төсөвгүй ажлыг төлөвлөгөөнд тусгахгүй байх,
3. Худалдан авах ажиллагаандаа дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, давуу эрх тооцохоор тендерийн баримт бичигт тусгах, дотоодын үйлдвэрлэгчийн худалдан авалтыг нэмэгдүүлэх,
4. Захиалагч гүйцэтгэгчдийн хооронд байгуулсан гэрээг тендерийн баримт бичигт тусгасан загварын дагуу хийх, гэрээ болон гэрээний хэрэгжилтийг цахим системд байршуулах,
5. Үнэлгээний хорооноос гарсан хурлын тэмдэглэл, шийдвэрийг Сангийн сайдын 2023 оны 254 дүгээр тушаалаар баталсан "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам"-д тусгасан загварын дагуу хийх,
6. Тендер шалгаруулалтын үр дүнг албажин гарсан өдрөөр цахим системд мэдээлэх,
7. Аудитын хүрээнд илэрсэн алдаа, зөрчлүүдийг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

ТАЙЛАН ХЯНАСАН:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга

ТАЙЛАН БИЧСЭН:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах шинжээч

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн

ТАНИЛЦСАН:

Төрийн нарийн бичгийн дарга

 Т.Баасанпүрэв

 И.Баттуяа

 Л.Мөнхгэрэл

 С.Магнайсүрэн